



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/195

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн М.Үүрийнтуяа (РЙ86110905)-гийн Булган сум 6 дугаар баг Залуус 7 дугаар гудамж 710 тоотод байршилтай 6308007587 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 574 м2 газрын газар эзэмших эрхийг П.Содтамир (ГЮ04250919)-д шилжүүлсүгэй.

2. П.Содтамиртай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/233 дугаар захирамжийн М.Үүрийнтуяатай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ